



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/35

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх “Авто замын зураг, төсөл боловсруулах ажил” (Сэргэлэн, Лүн, Зуунмод) -ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Я.Пагамаажав

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүдэд:

Б.Батбаяр

-Аймгийн ГХБХБГ-ын Газрын удирдлагын хэлтсийн дарга

С.Эрдэнэчимэг

-Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Д.Оюунсүвд

-Иргэний төлөөлөл /Лүн сумын ИТХ-ын Төлөөлөгч/

Нарийн бичгийн дарга:

Э.Номин-Эрдэнэ

-Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. “Авто замын зураг, төсөл боловсруулах ажил” (Сэргэлэн, Лүн, Зуунмод) -ын гүйцэтгэгчийг сонгох ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Я.Пагамаажав)-д, ашиг сонирхолын зөрчил, авилгаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг бологсугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Магнайбаяр)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригтоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. МӨНХБААТАР

412010134